




СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ


2025 II



www.1212.mn



ГАРЧИГ

ЕРӨНХИЙ ТЭМДЭГЛЭЛ		3
I	 ЭРҮҮЛ МЭНД	4-7
II	 ГЭМТ ХЭРЭГ	8-11
III	 ТӨСӨВ	12-15
IV	 АЖ ҮЙЛДВЭР	16-20

I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.


- Сар: I, II, III, IV, V ... г.м
- Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
- Өссөн дүн: I-IV, I-XI ... г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав).

II. Дараах тэмдэглэгээг ашиглав.

- ... мэдээлэл байхгүй
- 0.0 маш бага тоо
- - гүйцэтгэл байхгүй
- * урьдчилсан гүйцэтгэл

III. Хэмжих нэгжийн тэмдэглэгээ

- мянга =1000
- сая =10⁶
- тэрбум =10⁹
- их наяд =10¹²
- мян. мянга
- % хувь
- мм миллиметр
- см сантиметр
- дм дециметр
- м метр
- км километр
- м² метр квадрат
- дм² дециметр квадрат
- км² километр квадрат
- м³ метр куб
- га гектар
- мл миллилитр
- л литр
- г грамм
- кг килограмм
- цн центнер
- т тонн
- Вт ватт
- кВт.ц киловатт цаг
- кал калори
- ккал килокалори
- Гкал гигакалори (=10⁹ калори)
- с секунд
- мин минут
- мкг/м³ микрограмм метр куб
- м/с метр секунд
- ш ширхэг
- х.д.х хэвлэлийн даралтат хуудас

-  Үүнээс гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

IV. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.



V. Та цахим хэлбэрээр үзэж буй тохиолдолд тухайн салбарын логог дарж дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгтээр MS-Excel хэлбэрээр татан авах боломжтой.

/Жич: Интернетэд холбогдсон байх ёстой/



VI. Та өөрийн гар утаснаас QR code уншуулагч аппликейшн ашиглан тухайн салбарын хавсралт хүснэгтийг MS-Excel хэлбэрээр татан авч үзэх боломжтой.

/Жич: Интернетэд холбогдсон байх ёстой/



ЭРҮҮЛ МЭНД

2025 оны эхний 2 сарын байдлаар

ᠮᠠᠨᠢᠵᠡ
ᠲᠡᠷᠰᠡᠨ

Амаржсан эх



2024 II 899

2025 II 838

6.8% ↓

Шинээр төрсөн хүүхэд

2024 II 902

2025 II 844

6.4% ↓



Нийт халдварт өвчнөөр өвчлөгсөд



2024 II 416

2025 II 484

16.3% ↑



0-1 насны хүүхдийн
эндэгдэл

2024 II 15

2025 II 12

1-5 насны хүүхдийн
эндэгдэл

2024 II 2

2025 II 3



I. ЭРҮҮЛ МЭНД


Дүүргийн хэмжээнд 2025 оны эхний 2 дугаар сарын байдлаар 484 хүн халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 68 (16.3%) хүнээр, 10000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо 1.9 (15.4%) хүнээр өссөн байна. Халдварт өвчнөөр өвчлөгчдийн 23 (4.8%) цусан суулга, 7 (1.4%) улаан эсэргэнэ, 164 (33.8%) салхин цэцэг, 3 (1.2%) гар хөл, амны өвчин, 111 (22.9%) тэмбүү, 50 (10.3%) заг хүйтэн, 40 (8.3%) шинээр илэрсэн сүрьеэ, 57 (11.8%) трихомониаз өвчлөгчид тус тус эзэлж байна. Халдварт өвчнийг өмнөх онтой харьцуулахад цусан суулга 20 (46.5%), улаан эсэргэнэ 10 (58.8%), ГХА өвчин 8 (57.1%), шинэ илэрсэн сүрьеэ 8 (16.7%) тус тус буурсан байна. Харин салхин цэцэг 39 (31.2%), ёлом 1(20.0%), тэмбүү 44 (65.7%), заг хүйтэн 20 (66.7%), трихомониаз 9 (18.8%) хүнээр тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 1. ДҮҮРЭГТ ГАРСАН ХАЛДВАРТ ӨВЧИН, жил бүрийн 2 дугаар сарын байдлаар

Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	2023 I-II	2024 I-II	2025 I-II	Зэрүү	
					тоо /нэгж	хувь
НИЙТ ХАЛДВАРТ ӨВЧИН	Бодит тоо	303	416	484	68	16.3
	10000 хүнд	8.9	12.3	14.2	1.9	-
Үүнээс цочмог халдварт өвчин	Бодит тоо	158	223	226	3	1.3
	10000 хүнд	4.7	6.6	6.6	0	-
Цусан суулга	Бодит тоо	25	43	23	-20	-46.5
	10000 хүнд	0.7	1.3	0.7	-0.6	-
Улаан эсэргэнэ	Бодит тоо	4	17	7	-10	-58.8
	10000 хүнд	0.1	0.5	0.2	-0.3	-
Менингит	Бодит тоо	2	0	0	0	-
	10000 хүнд	0.1	0	0	-0.1	-
Гепатит	Бодит тоо	2	5	4	-1	-20.0
	10000 хүнд	0.1	0.1	0.1	0	-
Салхинцэцэг	Бодит тоо	109	125	164	39	31.2
	10000 хүнд	3.2	3.7	4.8	1.1	-
Гахайн хавдар	Бодит тоо	0	6	0	-6	-100.0
	10000 хүнд	0	0.2	0	-0.2	-
Сальмонеллэз	Бодит тоо	3	4	7	3	3.6 ¹
	10000 хүнд	0.1	0.1	0.2	0.1	-
Ёлом	Бодит тоо	0	5	6	1	20.0
	10000 хүнд	0	0.1	0.2	0.2	-
ГХА өвчин	Бодит тоо	12	14	6	-8	-57.1
	10000 хүнд	0.4	0.4	0.2	-0.2	-
Хоолны хордлого	Бодит тоо	0	4	0	-4	-100.0
	10000 хүнд	0	0.1	0	0.1	-
Тэмбүү	Бодит тоо	45	67	111	44	65.7
	10000 хүнд	1.3	2	3.2	1.2	-
Заг хүйтэн	Бодит тоо	21	30	50	20	66.7
	10000 хүнд	0.6	0.9	1.5	0.6	-
Шинэ илэрсэн сүрьеэ	Бодит тоо	47	48	40	-8	-16.7
	10000 хүнд	1.4	1.4	1.2	-0.2	-
Трихомониаз	Бодит тоо	32	48	57	9	18.8
	10000 хүнд	0.9	1.4	1.7	0.3	-

¹-дахин их

ЗУРАГ 1. ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ГАРАЛТ, ТӨРЛӨӨР



2025 оны эхний 2 дугаар сарын байдлаар 838 эхээс 844 хүүхэд мэндэлсэн байна. Өнгөрсөн оны мөн үед 474 эхээс 475 хүүхэд мэндэлж байжээ. Тайлант хугацаанд 0-1 насны хүүхдийн эндэгдэл 12 гарсан нь өмнөх оны мөн үеээс -3 (20%) буурсан байна. 1-5 насны хүүхдийн эндэгдэл 3 гарсан нь өмнөх оны мөн үеээс 1 (50%) - аар өссөн байна.

ХҮСНЭГТ 2. ТӨРСӨН ХҮҮХЭД, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, жил бүрийн 2 дугаар сарын байдлаар

Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Он			Зөрүү	
		2023 I-II	2024 I-II	2025 I-II	Тоо	Хувь
Амаржсан эхийн тоо	тоо	1000	899	838	-61	-6.8
Амьд төрсөн хүүхэд	тоо	1004	902	844	-58	-6.4
Нийт нас баралт	тоо	280	329	259	-70	-21.3
0-1 насны хүүхдийн эндэгдэл	тоо	11	15	12	-3	-20.0
1-5 насны хүүхдийн эндэгдэл	тоо	2	2	3	1	50.0
Төрөхийн улмаас эндсэн эх	тоо	0	1	0	-1	-100.0

2025 оны эхний 2 дугаар сарын байдлаар дүүргийн эмнэлгийн байгууллагууд 310301 үзлэг хийсний 131897 (42.5%) нь урьдчилан сэргийлэх, 51340 (16.5%) нь гэрийн үзлэг байна. Тус хугацаанд 104 эх шинээр жирэмсний хяналтад орсноос 5 (4.8%) нь цус багадалттай, 6 (5.8%) нь трихомониазийн өвчлөл эерэг гарсан байна. Шинээр хяналтанд орсон жирэмсэн эхчүүдийн 101 (97.1%) нь жирэмсний эхний 3 сартайдаа хяналтад орсон байна. 2025 оны эхний 2 дугаар сарын байдлаар артерийн гипертензи өвчний эрт илрүүлгийн үзлэгт 8820 хүн хамрагдсанаас 5390 (61.1%) эмэгтэйчүүд байна. Үүнээс давтан үзлэгт 245 (2.8%) нь хамрагдсан байна. Чихрийн шижин хэв шинж 2-ын эрт илрүүлгийн үзлэгт 5721 хүн хамрагдсанаас 3490 (61%) нь эмэгтэйчүүд байна. Эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан 35363 нийт хүний 20104 (56.9%) нь артерийн гипертензи өвчний эрт илрүүлгийн үзлэгт, 12828 (36.3%) нь чихрийн шижин хэв шинж 2-ын эрт илрүүлгийн үзлэгт, 2431 (6.8%) нь элэгний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгт тус тус хамрагдсан байна.

2025 оны эхний 2 дугаар сарын байдлаар 0-5 насны 11141 хүүхдийн өсөлтийн үндсэн үзүүлэлтийг шалгахад 0-5 насны хүүхдүүдийн 29 (0.3%) нь туранхай, 10 (0.08%) нь тураалтай, 22 (0.2%) нь өсөлтийн хоцрогдолтой хүүхэд байсан байна. Амбулатороор үйлчлүүлсэн 0-5 насны 61 хүүхэд А амин дэм, 5432 хүүхэд Д амин дэм тус тус уусан байна.

Ойлголт, тодорхойлолт:

Амьд төрөлт: Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байсан зэргийг (хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүй) хамруулна.

Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн жилд 0-28 хоногтой эндсэн хүүдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эхийн эндэгдлийн харьцаа (100000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд эндсэн эхийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эндсэн эх: Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэнийг хамруулна.

Эх үүсвэр: Сонгинохайрхан дүүргийн Эрүүд мэндийн төв



ГЭМТ ХЭРЭГ

2025 оны эхний 2 сард

Сүүдэр
Сүүдэр



Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг


2024 II

790

2025 II

1 097 38.9% ↑

Дүүргээр



Гэмт хэргийн улмаас



Хохирсон хүн

1 034



Гэмтсэн хүн

242



Нас барсан хүн

42



II. ГЭМТ ХЭРЭГ

2025 оны эхний 2 дугаар сарын байдлаар тус дүүрэгт нийт 1097 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 307 (38.9%) хэргээр өссөн байна. Нийт гэмт хэргийн 938 (85.5%) нь хөнгөн гэмт хэрэг бол 159 (14.5%) нь хүнд гэмт хэрэг эзлэж байна.

Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 37 (3.4%) хүний амьд явахын эсрэг, 4 (0.4%) хүнийг алах, 221 (20.1%) хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 1 (0.1%) хүний халдашгүй эрх чөлөөтэй байх эрхийн эсрэг, 13 (1.2%) хүчиндэх, 2 (0.2%) хүүхдийн эсрэг гэмт хэрэг, 265 (24.2%) хулгайлах, 37 (4.7%) дээрэмдэх, 303 (27.6%) залилах, 62 (5.7%) хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг, 137 (12.5) бусад хэрэг тус тус эзэлж байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралтыг өмнөх онтой харьцуулбар хүний амьд явахын эсрэг гэмт хэрэг 23 (2.6 дахин их), хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 5 (23.3%), хулгайлах гэмт хэрэг 97 (55.0%), дээрэмдэх гэмт хэрэг 37 (3.5 дахин их), залилах гэмт хэрэг 64 (26.8%), хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг (ХАБТХАЖЭ²) гэмт хэрэг 42 (3.1 дахин их), бусад гэмт хэрэг 45 (48.9%) тус тус өссөн үзүүлэлттэй байна. Харин хүнийг алах гэмт хэрэг 1 (20.0 Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг 1 (50.0%), хүчиндэх гэмт хэрэг 1 (7.1%) тус тус буурсан үзүүлэлттэй байна.

ХҮСНЭГТ 3.БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, төрлөөр, жил бүрийн эхний 2 дугаар сарын байдлаар

Үзүүлэлтийн нэр	2024 I-II	2025 I-II	Өөрчлөлт		Нийт гэмт хэрэгт эзлэх хувь	
	тоо	тоо	тоо	хувь		
Нийт гэмт хэрэг	790	1 097	307	38.9	100.0	
Гэмт хэргийн төрөл	Хүний амьд явахын эсрэг гэмт хэрэг	14	37	23	2.6 ¹	3.4
	Хүнийг алах	5	4	-1	-20.0	0.4
	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	216	221	5	2.3	20.1
	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг	2	1	-1	-50.0	0.1
	Хүчиндэх	14	13	-1	-7.1	1.2
	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	2	2	0	0.0	0.2
	Хулгайлах	171	265	94	55.0	24.2
	Дээрэмдэх	15	52	37	3.5 ¹	4.7
	Залилах	239	303	64	26.8	27.6
	ХАБТХАЖЭ ²	20	62	42	3.1 ¹	5.7
	Бусад	92	137	45	48.9	12.5

¹-дахин их

²Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг I-II өссөн дүн

Гэмт хэргийн илрүүлэлт:


2025 оны эхний 2 дугаар сарын байдлаар гэмт хэргийн илрүүлэлтийн хувь Улсын хэмжээнд 17.4 хувь, Нийслэлийн хэмжээнд 14.4 хувь байгаа бол Сонгинохайрхан дүүрэгт 21.3 хувь байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

ХҮСНЭГТ 4. ГЭМТ ХЭРГИЙН ИЛРҮҮЛЭЛТИЙН ХУВЬ, хэлтсээр, 2 дугаар сарын байдлаар

Хэлтэс	2024 I	2025 I	Өсөлт, бууралт
	Хувь		
Нийт илрүүлэлт	27.3	21.3	-6.0
СХДЦХ-1	22.5	17.7	-4.8
СХДЦХ-2	40.9	22.1	-18.8
СХДЦХ-3	27.5	26.8	-0.7

Цагдаагийн 1 дүгээр хэлтэст гэмт хэргийн илүүрэлт 17.7 хувь байгаа нь өмнөх оны мөн үеэс 4.8 хувиар, Цагдаагийн 2 дугаар хэлтэст гэмт хэргийн илэрүүлэлт 22.1 хувь байгаа нь 18.8 хувиар, Цагдаагийн 3 дугаар хэлтэст гэмт хэргийн илэрүүлэлт 26.8 хувь байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.7 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

ЗУРАГ 2. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, хэлтсээр, 2025 оны эхний 2 дүгээр сарын байдлаар



Нийт бүртгэгдсэн 1097 гэмт хэргийн 510 (46.5%) цагдаагийн 1 дүгээр хэлтэст, 301 (27.4%) цагдаагийн 2 дугаар хэлтэст, 286 (26.1%) цагдаагийн 3 дугаар хэлтэст тус тус бүртгэгдсэн байна.

ХҮСНЭГТ 5. ЗӨРЧЛИЙН МЭДЭЭ, хэлтсээр

Хэлтэс	2024 I-II	2025 I-II	Өөрчлөлт		Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
	тоо		тоо	хувь	
Нийт зөрчил	8 470	7 743	-727	-8.6	100.0
СХДЦХ-1	2 951	4 204	1 253	42.5	54.3
СХДЦХ-2	2 629	1 263	-1 366	-52.0	16.3
СХДЦХ-3	2 890	2 276	-614	-21.2	29.4

Дүүргийн хэмжээнд 2025 оны эхний 2 дугаар сарын байдлаар 7743 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 727 (8.6%) зөрчлөөр буурсан үзүүлэлттэй

байна. Зөрчил гаргасан 7 204 иргэн, 13 хуулийн этгээдийг мөнгөн торгуулиар торгож, 109 хүнийг баривчлах шийтгэл оногдуулсан байна. Нийт бүртгэгдсэн зөрчлийн 4204 (54.3%) нь цагдаагийн I хэлтэст, 1263 (16.3%) нь цагдаагийн II хэлтэст, 2276 (29.4%) нь цагдаагийн III хэлтэст тус тус бүртгэгдсэн байна.

Ойлголт, тодорхойлолт:

Гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг: Тухайн хугацаанд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоог 16, түүнээс дээш насны хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 10000- аар үржүүлж тооцно.

Хохирогч: Монгол Улсын "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай" хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно.

Гэмт хэргийн хохирол: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

Яллагдагч: Монгол Улсын "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай" хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.


Эх үүсвэр: Сонгинохайрхан дүүрэг дэх Цагдаагийн газрын бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын мэдээ




ДҮҮРГИЙН ТӨСӨВ

2025 оны 2 сард, тэрбум төгрөгөөр

Авчир




Төсвийн орлогын бүтэц



- Татварын орлого
- Татварын бус орлого

Татварын орлогын бүтэц



- Орлогын албан татвар
- Өмчийн татвар
- Бусад татвар



III. ДҮҮРГИЙН ТӨСӨВ

Дүүргийн төсвийн нийт орлого 2025 оны эхний 2 дугаар сарын байдлаар 24014.5 сая төгрөг болж, төлөвлөснөөс 6058.0 (20.1%) сая төгрөгөөр дутуу бүрджээ. Төсвийн нийт орлогын 23155.4 (96.4%) сая төгрөгийг татварын орлого, 859.1 (3.6%) сая төгрөгийг татварын бус орлого тус тус бүрдүүлжээ.

Нийт татварын орлогын 19836.2 (85.7%) сая төгрөгийг хувь хүний орлогын албан татвар, 410.6 (1.8%) сая төгрөгийг хөрөнгийн албан татвар, 2908.6 (12.5%) сая төгрөгийг бусад татвар, төлбөр хураамжаас тус тус бүрдүүлжээ.


ХҮСНЭГТ 6. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, 2025 оны эхний 2 дугаар сарын байдлаар

Үзүүлэлтийн нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өсөлт, бууралт	
	2025 I-II			
	сая төгрөг		дүн	хувь
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	30 072.5	24 014.5	-6 058.0	-20.1
Татварын орлого	28 930.6	23 155.4	-5 775.2	-20.0
Орлогын албан татвар	25 426.2	19 836.2	-5 590.0	-22.0
Хувь хүний орлогын албан татвар	25 426.2	19 836.2	-5 590.0	-22.0
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	13 200.0	10 810.2	-2 389.8	-18.1
Үйл ажиллагааны орлого	1 350.0	1 510.8	160.8	11.9
Хөрөнгийн орлого	2 775.0	2 333.1	-441.9	-15.9
Хөрөнгө борлуулсны орлого	950.0	1 094.1	144.1	15.2
Шууд бус орлого	7 151.2	4 088	-3 063.2	-42.8
Хөрөнгийн албан татвар	403.9	410.6	6.7	1.7
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	400.0	403.4	3.4	0.8
Бууны албан татвар	3.0	4.3	1.3	43.3
Малд ногдуулах албан татвар	0.9	2.9	2.0	3.2 ¹
Бусад татвар, төлбөр, хураамж	3 100.5	2 908.6	-191.9	-6.2
Бусад нийтлэг төлбөр, хураамж	1 095.1	1 189.2	94.1	8.6
Улсын тэмдэгтийн хураамж	429.7	94.3	-335.4	-78.1
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	9.8	0	-9.8	-100.0
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	655.6	1 094.9	439.3	67.0
Газрын төлбөр	2 004.2	1 712.2	-292.0	-14.6
Байгалийн нөөц ашигласны төлбөр	1.2	7.2	6.0	6 ¹
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	1.2	7.2	6.0	6 ¹
Татварын бус орлого	1 141.9	859.1	-282.8	-24.8
Нийтлэг татварын бус орлого	553.9	631.1	77.2	13.9
Торгуулийн орлого	457.9	522.4	64.5	14.1
Төсөв байгууллагын өөрийн орлого	21.0	19.6	-1.4	-6.7
Бусад орлого	75.0	89.1	14.1	18.8
Орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг	588.0	228.0	-360.0	-61.2

¹-дахин их

2025 оны эхний дугаар сарын байдлаар татварын орлогын хэмжээ 23155.4 сая төгрөг болж, төлөвлөснөөс 5775.2 (20.0%) төгрөгөөр, татварын бус орлого 859.1 сая төгрөг болж, төлөвлөснөөс 282.8 (24.8%) сая төгрөгөөр тус тус дутуу бүрдсэн байна. Харин хөрөнгийн албан татварвар 410.6 болж төлөвлөснөөс 6.7 (1.7%) сая төгрөгөөр илүү бүрдүүлсэн байна. Нийт хөрөнгийн албан татварын 403.4 (98.2%) сая төгрөгийн үл хөдлөх хөрөнгийн албан татвар, 4.3 (1.0%) сая төгрөгийг бууны албан татвараас тус тус бүрдүүлсэн байна.

ЗУРАГ 3. ТӨСВИЙН ОРЛОГО, сая төг



Дүүргийн төсвийн нийт зардал 2025 оны эхний 2 дугаар сарын байдлаар 19568.2 сая төгрөг болж, төлөвлөснөөс 23289.3 (54.3%) сая төгрөгөөр дутуу зардал хэмнэсэн байна. Төсвийн нийт зардлын 16099.7 (82.3%) сая төгрөгийг бараа, ажил үйлчилгээний зардалд, 3468.5 (17.7%) сая төгрөгийг урсгал шилжүүлэгт тус тус зарцуулжээ. Нийт бараа, ажил үйлчилгээний зардлы 3057.3 (19.0%) сая төгрөгийг цалин хөлс нэмэгдэл урамшуулалд, 343.8 (2.1%) сая төгрөгийг ажил олгогчоос нийгмийн даатгалд, 4230.4 (26.3%) сая төгрөгийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд, 2127.9 (13.2%) сая төгрөгийг хангамж, бараа материалын зардалд, 5355.9 (33.3%) бараа үйлчилгээний бусад зардалд тус тус зарцуулсан байна.

ХҮСНЭГТ 7. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, 2025 оны эхний 2 дугаар сарын байдлаар

Үзүүлэлтийн нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өсөлт бууралт	
	сая төгрөг		дүн	хувь
НИЙТ ЗАРЛАГА	42 857.5	19 568.2	-23 289.3	-54.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	24 635.5	16 099.7	-8 535.8	-34.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3 296.4	3 057.3	-239.1	-7.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	412.1	343.8	-68.3	-16.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6 552.2	4 230.4	-2 321.8	-35.4
Хангамж, бараа материалын зардал	2 835.5	2 127.9	-707.6	-25.0
Нормативт зардал	19.4	5.2	-14.2	-73.2
Эд хогшил, урсгал засварын зардал	961.6	381.8	-579.8	-60.3
Томилолт, зочны зардал	143.4	0	-143.4	-100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1 682.8	597.4	-1 085.4	-64.5
Бараа үйлчилгээний бусад зардал	8 732.1	5 355.9	-3 376.2	-38.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3 583.7	3 468.5	-115.2	-3.2
Засгийн газрын урсгал шилжүүлэг	3 293.1	3 293.1	0.0	0.0
Бусад урсгал шилжүүлэг	290.6	175.4	-115.2	-39.6
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	14 638.3	0	-14 638.3	-100.0

Ойлголт, тодорхойлолт:

Татварын орлого: Орлогын албан татвар, нийгмийн даатгалын орлого, хөрөнгийн албан татвар, нэмэгдэл өртгийн албан татвар, онцгой албан татвар, тусгай зориулалтын орлого, гадаад үйл ажиллагааны орлого, бусад татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ.

Татварын бус орлого: Нийтлэг татварын бус орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлого, улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгээс бүрдэнэ.

Төсвийн орлого: Ирээдүйн өв сан, тогтворжуулалтын сан болон тэнцвэржүүлсэн орлогоос бүрдэнэ.


Урсгал зардал: Бараа, ажил, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс бүрдэнэ.




АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ 2025 оны эхний 2 сарын байдлаар

МОНГОЛЫН УС ХААНГАМЖ, СУВАГЖИЛТЫН СИСТЕМ, ХОГ ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛАХ БОЛОН ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧНЫГ ДАХИН СЭРГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Бүтээгдэхүүн үйлдвэрлэл, тэрбум төгрөгөөр



Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа, тэрбум төгрөгөөр






IV. АЖ ҮЙЛДВЭР

Дүүргийн аж үйлдвэрийн байгууллагууд 2025 оны эхний 2 дугаар сарын байдлаар 303.6 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 266.4 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад үйлдвэрлэлт 20.7 хувиар, борлуулалт 11.6 хувиар тус тус өссөн байна.

ЗУРАГ 4. АЖ ҮЙЛДВЭРИЙН ҮЙЛДВЭРЛЭЛТ, БОРЛУУЛАЛТ, тэрбум төгрөгөөр



Боловсруулах аж үйлдвэрийн салбарт, хиам 767.8 тонн үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 105.5 (12.1%) тонноор, тараг 785.4 мянган литр үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 383.0 (32.8%) мянган литрээр, буудайн I зэргийн гурилт 4117.0 тонн үйлдвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 1369.5 (25.0%) тонноор ус тус буурсан байна. Харин мах 5298.5 тонн үйлдвэрлэсэн нь өмнөх оны мөн 741.1 (16.3%) тонноор, Цөцгийн тос 138.5 тонн үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 107.6 (4.5 дахин их) тонноор, боловсруулсан шингэн сүү 5702.2 мянган литр үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 819.8 (16.8%) мянган литрээр, нарийн боов 1100.8 тонн үйлдвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 333.1 (43.4%) тонноор тус тус өссөн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна.

ХҮСНЭГТ 8. АЖ ҮЙЛДВЭРИЙН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ
2025 оны эхний 2 дугаар сарын байдлаар

Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2024 I-II	2025 I-II	Өөрчлөлт	
		дүн	дүн	дүн	хувь
Мах	тн	4 557.4	5 298.5	741.1	16.3
Хиам	тн	873.3	767.8	-105.5	-12.1
Боловсруулсан шингэн сүү	мян.л	4 882.4	5 702.2	819.8	16.8
Тараг	мян.л	1 168.4	785.4	-383.0	-32.8
Цөцгийн тос	тн	30.9	138.5	107.6	4.5 ¹
Аарц	тн	118.2	231.6	113.4	95.9
Улаанбуудайн дээд гурил	тн	2 854.1	3 253.0	398.9	14.0
Буудайн I зэргийн гурил	тн	5 486.5	4 117.0	-1 369.5	-25.0
Буудайн II зэргийн гурил	тн	1 074.2	1 031.0	-43.2	-4.0
Талх	тн	2 732.1	3 157.1	425.1	15.6
Нарийн боов	тн	767.8	1 100.8	333.1	43.4
Гоймон	тн	518.3	360.3	-158.0	-30.5
Цагаан архи	мян.л	660.2	489.2	-171.0	-25.9
Шахмал эм	мян.боодол	2 137.0	2 679.0	542.0	25.4
Шингэн эм	тн	4.8	7.1	2.3	49.0
Нүүрсэн шахмал түлш	тн	109 600.0	124 747.3	15 147.3	13.8

¹дахин их

ХҮСНЭГТ 9. АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛТ, салбараар
2025 оны эхний 2 дугаар сарын байдлаар

Салбар	Нийт бүтээгдэхүүн			
	2024 I-II	2025 I-II	Өөрчлөлт	
	сая төгрөг		дүн	хувь
БҮГД	251 420.9	303 576.6	52 155.7	20.7
УУЛ УУРХАЙ,ОЛБОРЛОЛТ	0	2 029.1	2 029.1	-
Өнгөт төмөрлөгийн хүдэр олборлолт	0	2 029.1	2 029.1	-
БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛ	248 073.4	297 710.6	49 637.2	20.0
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	156 693.2	191 592.1	34 898.9	22.3
Мах боловсруулах, консервлох	55 303.7	70 041.8	14 738.1	26.6
Жимс болон төмс, хүнсний ногоо боловсруулалт, хадгалалт	25.3	3.8	-21.5	-85.0
Сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	46 225.1	62 512.2	16 287.1	35.2
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	30 702.2	40 244.3	9 542.1	31.1
Үр тарианы гурлын болон цардууллаг бүтээгдэхүүн	24 436.9	18 790.0	-5 646.9	-23.1
Ундаа үйлдвэрлэл	13 863.9	11 147.0	-2 716.9	-19.6
Ээрэх, нэхэх, даавуун материал бэлтгэх үйлдвэрлэл	8 193.9	15 122.2	6 928.3	84.6
Хувцас үйлдвэрлэл	1 249.1	1 088.3	-160.8	-12.9
Арьс, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	1 414.7	640.0	-774.7	-54.8
Хэвлэх, дуу бичлэгийг хувилах, дахин үйлдвэрлэх үйл ажиллагаа	515.8	323.4	-192.4	-37.3
Кокс болон газрын түүхий тосны боловсруулсан бүтээгдэхүүн	55 304.2	62 163.7	6 859.5	12.4
Химийн бодис болон химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	3 307.9	5 531.2	2 223.3	67.2
Үндсэн эмийн бүтээгдэхүүн болон эмийн бэлдмэлийн үйлдвэрлэл	2 483.5	4 499.3	2 015.8	81.2
Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл	74.6	38.7	-35.9	-48.1
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	4 598.8	5 280.6	681.8	14.8
Машин, тоног төхөөрөмжөөс бусад металл бүтээгдэхүүн үйлдвэрлэл	157.1	0.3	-156.8	-99.8
Цахилгаан тоног төхөөрөмж үйлдвэрлэл	22.5	22.5	0.0	0.0
Тавилга үйлдвэрлэл	116.2	190.8	74.6	64.2
Боловсруулах бусад үйлдвэрлэл	78	70.5	-7.5	-9.6
УС ХАНГАМЖ; СУВАГЖИЛТЫН СИСТЕМ, ХОГ ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛАХ БОЛОН ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫГ ДАХИН СЭРГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	3 347.5	3 836.9	489.4	14.6
Хог хаягдлыг цуглуулах, боловсруулах, зайлуулах; дахин ашиглах	3 347.5	3 836.9	489.4	14.6

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2025 оны эхний 2 дугаар сарын байдлаар 303.6 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 52.2 (20.7%) тэрбум төгрөгөөр өсөхөд, химийн бодис болон химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2.2 (67.25%) тэрбум төгрөгөөр, Үндсэн эмийн бүтээгдэхүүн болон эмийн бэлдмэлийн үйлдвэрлэл 2.0 (81.2%), кокс болон газрын түүхий тосны боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл 6.9 (12.4%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлсөн байна. Нийт аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 2.0 (0.6%) тэрбум төгрөгийг уул уурхайн олборлолт, 297.7 (98.1%) тэрбум төгрөгийг боловсруулах

үйлдвэрлэл, 3.8 (1.3%) тэрбум төгрөгийг ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа үйлдвэрлэл тус тус бүрдүүлж байна.

ХҮСНЭГТ 10. АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОРЛУУЛАЛТ, салбараар
2025 оны эхний 2 дугаар дүээр сарын байдлаар

Салбар	Нийт бүтээгдэхүүн			
	2024 I	2025 I	Өсөлт, бууралт	
	сая төгрөг			Хувь
БҮГД	240 031.6	266 641.2	26 609.5	11.1
УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОЛТ	0	2 029.1	2 029.1	-
Өнгөт төмөрлөгийн хүдэр олборлолт	0	2 029.1	2 029.1	-
БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛ	236 678.4	260 801.7	24 123.2	10.2
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	170 855.2	187 252.4	16 397.2	9.6
Мах боловсруулах, консервлох	53 319.8	5 889.1	5 571.2	10.4
Жимс болон төмс, хүнсний ногоо боловсруулалт, хадгалалт	25.3	4.2	-21.1	-83.4
Сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	51 500.4	69 994.2	18 493.8	35.9
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	3 605.3	42 505.6	6 452.6	17.9
Үр тарианы гурилын болон цардууллаг бүтээгдэхүүн	29 956.7	15 857.4	-14 099.3	-47.1
Ундаа үйлдвэрлэл	20 658.5	24 087.7	3 429.1	16.6
Ээрэх, нэхэх, даавуун материал бэлтгэх үйлдвэрлэл	7 097.8	14 833.3	7 735.5	2.1 ¹
Хувцас үйлдвэрлэл	1 201.7	1 647.1	445.5	37.1
Арьс, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	499	160	-339	-67.9
Хэвлэх, дуу бичлэгийг хувилах, дахин үйлдвэрлэх үйл ажиллагаа	515.8	404.3	-111.5	-21.6
Кокс болон газрын түүхий тосны боловсруулсан бүтээгдэхүүн	2 393.0	18 612.3	-5 317.7	-22.2
Химийн бодис болон химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	2 813.1	3 497.7	684.6	24.3
Үндсэн эмийн бүтээгдэхүүн болон эмийн бэлдмэлийн үйлдвэрлэл	3 403.9	4 125.4	721.5	21.2
Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл	74.6	66.6	-8	-10.7
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	5 267.7	5 823.1	555.3	10.5
Машин, тоног төхөөрөмжөөс бусад металл бүтээгдэхүүн үйлдвэрлэл	141.8	0.5	-141.3	-99.6
Цахилгаан тоног төхөөрөмж үйлдвэрлэл	25	30	5	20.0
Тавилга үйлдвэрлэл	116.3	190.8	74.5	64.1
Бусад боловсруулах үйлдвэрлэл	78	70.5	-7.5	-9.6
УС ХАНГАМЖ; СУВАГЖИЛТЫН СИСТЕМ, ХОГ ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛАХ БОЛОН ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫГ ДАХИН СЭРГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	3 353.2	3 810.4	457.2	13.6
Хог хаягдлыг цуглуулах, боловсруулах, зайлуулах; дахин ашиглах	3 353.2	3 810.4	457.2	13.6

¹дахин их

Аж үйлдвэрийн салбарын нийт борлуулалт 2025 оны эхний 2 дугаар сарын байдлаар 266.6 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 26.6 (11.1%) тэрбум төгрөгөөр өсөхөд уул уурхайн олборлолт 2.0 тэрбум төгрөгөөр, боловсруулах үйлдвэрлэлийн салбар 24.1 (10.2%) тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ. Тодруулбал ээрэх, нэхэх, даавуун материал бэлтгэх үйлдвэрлэл 7.7 (2.1дахин их) тэрбум төгрөгөөр, сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл 18.4 (35.9%) тэрбум төгрөгөөр, хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл 6.4 (17.9%) тэрбум төгрөгөөр, ундаа үйлдвэрлэл 3.4 (16.6%) тэрбум төгрөгөөр тус бүр өссөн байна. Нийт борлуулалтын 260.8 (97.8%) тэрбум төгрөгийг боловсруулах үйлдвэрлэл эзэлж

байгаа бөгөөд хүнсний бүтээгдэхүүний борлуулалт 211.3 (79.2%) тэрбум төгрөг, хүнсний бус бүтээгдэхүүний борлуулалт 5.8 (20.8%) тэрбум төгрөг тус тус эзэлж байна үйлдвэрлэл, 2.2 (1.8%) тэр бум төгрөгийг ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах, хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа борлуулалт тус тус эзэлжээ.

Ойлголт, тодорхойлолт:

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн: Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл: Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Эдийн засгийн үйл ажиллагааны ангилал: НҮБ-аас гишүүн орнууддаа мөрдөхийг зөвлөмж болгосон эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны олон улсын стандарт ангилалд нийцүүлэн боловсруулсан үндэсний ангилал юм.

Танилцуулгыг хянасан:

Б.Баатарцогт

Г.Батцэцэг

Танилцуулгыг бэлтгэсэн:

Г.Батцэцэг

Аж үйлдвэр

О.Үүрийнцолмон

Эрүүл мэнд

Т.Баянмөнх

Дүүргийн төсөв

С.Удвал

Гэмт хэрэг

Танилцуулгыг нэгтгэсэн:

С.Удвал

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ХОЛБОО БАРИХ:

Утас: 70171660, 70171322

E-mail: Songinokhairkhan@nso.mn